

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ
ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (2022 он)
Баян-Өлгийн Эрүүл мэндийн газар

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	485	412	Тайлангийн жилд 21 эрүүл мэндийн байгууллагын албан хаагчид 412 удаагийн сургалтад давхардсан тоогоор 4725 эрүүл мэндийн ажилтан хамрагдаж, мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн. Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан.
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	60	57	Аймгийн нэгдсэн эмнэлгийн давхардсан тоогоор 1783 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд доорх сэвэв бүхий 17 удаагийн ажлын байрны сургалтад хамрагдсан байна. “Унаж бэртэх эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга”, “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах”, “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”, “уян зүү тавих арга зүй”, “Амилуулах суурь тусламж”, “Сорьц авах ба сорьц цуглуулах тээвэрлэх арга”, “Өндөр эрсдэлтэй эм ба эмийн зөв зохистой хэрэглээ”, “Сувилахуйн тусламж үзүүлэх арга ба 5 шатлалаар СТ-бичих арга”, “Хүнд өвчтөний асаргаа сувилгаа”, “Цооролт, холболтын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээ”, “Уян зүү тавих стандарт, халдвараас сэргийлэх, тандалт хийх аргачлал”, “Шинэ сувилагч бэлтгэх сургалт”, “Цус харвалт буюу хэвтрийн өвчтөний асаргаа сувилгаа”, “Сувилагч цус, цусан бүтээгдэхүүнийг сэлбэхэд анхаарах зүйлс”, “ЭМС-263, А/318, А/550-тоот тушаалын тухай”, “Эрсдэлийн удирдлага”, “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын 6-зорилт”, “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой үүссэн тохиолдлыг бүртгэх, мэдээлэх хариу арга хэмжээ авах тухай”, “Цочмог халууралт, цэврүүт, цусархаг, тууралт халдварт өвчин”, мөн Анхан шатны эмч, эмнэлгийн зарим эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг,

					нэгдсэн эмнэлгийн тасгуудад 7 хоногоор ажлын байрны сургалтад хамруулан ажилласан.
			Мэргэшүүлэх сургалт	85	61
					Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлтийн дагуу салбар нэгжүүдээс 2022-2023 онд улсын төсвийн санхүүжилтээр, байгууллагын зардлаар суралцуулах эмч, эмнэлгийн мэргэжилтний захиалгыг хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/162 дугаар тушаалаар батлагдсан хязгаарын дагуу эмч мэргэжилтнүүдийг мэргэшлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцуулж байна. Тайлангийн жилд үндсэн мэргэшлийн сургалтад Дотрын анагаах судлал 1, Эх барих эмэгтэйчүүд судлал 1, Хүүхэд судлал 3, Сэргээн засал судлалаар 3, нийт 8 эмчийг, төрөлжсөн мэргэшлийн 6 сарын сургалтад 7 их эмч, мэргэжил дээшлүүлэх сургалтад 12 эмчийг хамруулсан бол сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний 1-3 сарын төрөлжсөн мэргэшлийн болоод мэргэжил дээшлүүлэх сургалтад 20 мэргэжилтэнг, Түүнчлэн төрөх тасгийн Эх барих эмэгтэйчүүдийн нэг эмчийг Америк улсад, Зүрх судасны чиглэлээр нэг эмчийг Испани улсад богино хугацааны сургалтад. Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн дагуу Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад Төрийн захиргааны Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт 1 удирдах ажилтан, 29.1-р зүйлд “Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад хамруулна” гэж заасны дагуу Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 2 мэргэжилтэнг, “ажлаасаа хөндийрөлгүйгээр “зайн сургалтад хамруулсан. АШУҮИС-тай хамтран ажиллах гэрээний дагуу Эм зүйн удирдлага зохион байгуулалтын 6 сарын төрөлжсөн мэргэшлийн сургалтад аймгийн төвийн хувийн эмийн сангуудын 8 эм зүйч, ЭМГазрын эмийн мэргэжилтэн нийт 9 эм зүйчийг цахим сургалтад хамруулан ажиллаж байна.

			Туршлага солилцох арга хэмжээ	8	4	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн нэг эмч, нэг сувилагч Улсын нэгдүгээр төв эмнэлэгт бөөрний дурангийн мэс заслын 14 хоногийн сургалтад, Нэгдүгээр эмнэлгийн Бөөрний мэс заслын эмч, хагалгааны сувилагч нар орон нутагт ирж сургалт зохион байгуулан хагалгааны эмч, сувилагчдыг ажлын байранд нь дагалдан сургав. Мөн нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасгийн нүдний эмч ОУБ-ын санхүүжилтээр ЭХЭМҮТөвд 28 хоногийн дадлагажуулах сургалтад тус тус хамрагдсан. Гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн эмч, сувилагчид яаралтай тусламжийн тасагт, мөн эдийн засагч, нягтлан бодогч даатгал, мэдээлэл технологийн ажилтан, статистикийн ажилтнууд Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн ажлын байрны туршлага судлах сургалтад хамруулсан.
			Бусад	25	28	Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан.
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	1141	1105	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	836	815	
			Эрэгтэй албан хаагч	305	290	
			Удирдах албан тушаалтан	26	26	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	1115	1079	
		1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад	95%	90 %	Мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад 2022 оны хүний нөөцийн сургалтын төлөвлөлтийн дагуу 85% хэрэгжсэн бол байгууллагуудын дотоод сургалт, зайн сургалтад албан хаагчдыг тогтмол хамруулан ажилласан.

			эзлэх хувь			Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч эмнэлгийн мэргэжилтнүүд HRDS (hdc.gov.mn) программаар хүсэлт илгээж багц цагийн сургалтад хамрагдан багц цагаа бүрдүүлсэн.
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	10	4	Аймгийн НЭ-ийн төрөх тасгийн Эх барих эмэгтэйчүүдийн нэг эмчийг Австрийн санхүүжилтийн “Open medical institute” –сургалтад, Европын зүрхний нийгэмлэг-Конгресс 2022 Испани-Барселон хот зүрхний их эмч богино хугацааны сургалтад, Аймгийн ЗӨСТөвийн дарга ОХУ-ын Ташанта боомтод 3 хоногийн “Хил дамнан халдварлах тарваган тахал өвчний хариу арга хэмжээ” үзүүлэх сургалтад, Мөн ОХУ-ын Эрхүү хотын Тарваган Тахал Эсэргүүцэн Судлах Эрдэм Шинжилгээний Хүрээлэнгээс ЗӨСҮТөв дээр зохион байгуулсан биологичийн 6 хоногийн мэргэшүүлэх сургалтад нэг ажилтан тус тус хамрагдсан.
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	0	4	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	0	3	
			Эрэгтэй албан хаагч	0	1	
			Удирдах албан тушаалтан	0	1	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	0	3	
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	0	4	
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)			Төрийн зардлаар мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын үндсэн цалинг Төрийн албаны тухай хуулийн холбогдох заалтын дагуу, Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтаар 5 жил тутамд мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдад Эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 56/97 дугаар хамтарсан тушаалын дагуу 3 хүртэлх сарын үндсэн цалин, замын зардлыг үндсэн байгууллагаас гэрээний дагуу төлж байна. 11сарын байдлаар төгсөлтийн дараах сургалтад 61 гаруй эмч эмнэлгийн мэргэжилтэн, Улаанбаатар хот БОЭТөв, аймгийн төвд зохион байгуулагдсан сургалтад давхардсан тоогоор 450 гаруй эрүүл мэндийн ажилтан хамрагдаж томилолт, замын зардлыг шийдвэрлүүлсэн байна. Эхний 11 сарын байдлаар Нэгдсэн эмнэлэг 5.4

						сая, ЗӨСТөв 0.7 сая төгрөг, Өрхийн ЭМТөвүүд 1.6 сая, Сумын ЭМТөвүүд 20.4 сая нийт 28.1 сая, төгрөг олгогдсон.
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь		1%	27 их эмч, 32 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, 25 эрүүл мэндийн бусад ажилтан ажлын байраар тус тус хангагдсан байна.
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	16626.3 сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 52.4%	15745.9 сая төгрөг нийт төсөвт эзлэх хувь 52.3%	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5, 25, 395, 276, 2018 оны 382 дугаар 2022 оны 107 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллаж байна.Биелэлт нь 94,7%-тай байна.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	ЭМГ-т 5000, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 1000, аймгийн бусад эрүүл мэндийн байгуулл ага 3000 төгрөгөөр тус тус тооцож олгох.	ЭМГ 5000, сум, тосгоны эрүүл мэндийн төвд 1000, аймгийн бусад эрүүл мэндийн байгуулл ага 3000 төгрөгөөр тус тус тооцож олгож ажилласан.	Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 дугаар тушаалаар тогтоож өгсөн эрүүл мэндийн салбарын төрийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоол, унааны хөнгөлөлтийг хэмжээг хэрэгжүүлэн ажилласнаар 2022 онд салбарын хэмжээнд 400,2 сая төгрөг зарцуулж, нийт төсвийн 1,3%-ийг эзэлж байна. Биелэлт нь 100% байна.
5.	Албан хаагчдын		Ажлын байрны таатай орчны			Аймагт үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн

	ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	90%	86%	байгууллагууд ЭМС-ын 2014 оны 13 дугаар тушаалын дагуу сэтгэл ханамжийн судалгааг нэгдсэн аргачлал, асуулгаар, өөрсдийн төлөвлөгөөний дагуу ажилчдаас тодорхой давтамж, үе шаттай авч зохион байгуулсан. Судалгааны үр дүнг шийдвэр гаралт, төлөвлөлтөд ашиглаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар үйлчилгээ үзүүлэгчдэд тухай бүрт мэдээлж байв. (Энэ талаар Хэрэглэгчийн үнэлгээний тайланд дэлгэрэнгүй бичигдсэн) Эмч, эмнэлгийн ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшин 85% байна.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	85%	75%	Эрүүл мэндийн салбарын ажилчдыг хуваарийн дагуу урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан. 2022 онд шинээр В гепатит 24, С гепатит 31 тус тус илэрч 34 албан хаагч эмчилгээнд хамрагдсан. Тайлангийн жилийн эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор 778 эрүүл мэндийн ажилтан хэвтэн эмчлүүлсэн. Хэрэгжилт 75 %.
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	85%	75%	Аймгийн эрүүл мэндийн салбарын нийт албан хаагчдын 75% нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	Төлөвлөлийн дагуу	Тайлант оны гүйцэтгэлээр	Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтнуудын цалинг тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон. Аймгийн нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих сар"-ын хүрээнд албан хаагчдын цалинг 15-20%-р нэмэгдүүлсэн. - Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн байгууллагууд Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулан ажилтны нийгмийн баталгааны чиглэлээр тодорхой заалтуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дугаар заалтаар зүйлийн дагуу 171 эмнэлгийн мэргэжилтэнд 800.500.000 төгрөг, 29.2 заалтаар 10

					эмнэлгийн мэргэжилтэнд 227.500.000 сая төгрөг олгогдсон. Эрүүл мэндийн яамнаас ипотекийн авахыг хүссэн ч урьдчилгаа төлбөр нь хүрэлцэхгүй байгаа эрүүл мэндийн ажилтнуудын урьдчилгаа төлбөрийн тодорхой хэсэгт батлан даалт гаргах чиглэлээр судалгаа хийсэн үг судалгаанд 350 гаруй эрүүл мэндийн ажилтан оролцов. Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтнуудаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан ажилласан нийт эрүүл мэндийн ажилтнуудын 75% хамрагдсан. Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх ҮЭ-ийн салбар хорооноос 2021 оны шилдгээр шалгарсан 19 эрүүл мэндийн ажилтныг Хужирт рашаан сувилалд амраасан. Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүд байгууллагын албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг жилд 1-2 удаа зохион байгуулж, албан хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар ханган ажилласан. Эхний 11 сарын байдлаар Нэгдсэн эмнэлэг 21,3 сая, ЗӨСТөв мянган төгрөг , Өрхийн ЭМТөвүүд 3,5 сая, Сумын ЭМТөвүүд 35 сая, нийт 59,8 сая, төгрөг зарцуулсан байна. Хөдөө сумдад ажиллаж байгаа зарим эмч нарыг орон нутгаас нь орон байраар ханган ажиллаж байна. Үүнд: Ногооннуур сумын сум дундын эмнэлгийн 1, Цагааннуур тосгоны эрүүл мэндийн төвд 2 эмнэлгийн мэргэжилтэн, Алтанцөгц сумын 1 багийн бага эмчийг, Буянт, Булган, Улаанхус, Толбо сумын ЭМТөвүүд тус бүр 1 эрүүл мэндийн ажилтанг тухайн эрүүл мэндийн харьяанд байгаа эмнэлгийн орон сууцаар хангасан.
--	--	--	--	--	--

Ерөнхий үнэлгээ 90%.

Нэгтгэсэн: ЭМГ-ын Хүний нөөцийн мэргэжилтэн

Б.Нуржайна